

БАТЛАВ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

БАТЛАВ
“МӨНХӨЛЗИЙ АЛТ МӨНГӨН ГАДАС”
ХХК-НЫ ЗАХИРАЛ

 С.МӨНХБАТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД ХИЙГДЭХ
“АХМАДЫН БАЙРНЫ ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ АЖЛЫН ГЭРЭЭ
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202301003

2023 оны 05 дугаар сарын 10

Хараат

Нэг талаас (цаашид “Захиалагч” гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “Мөнхөлзий алт мөнгөн загас” ХХК-ны захирал С.Мөнхбат (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 11 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Ахмадын байрны засвар, үйлчилгээ” -ний ажлыг ДУГАЦДСЗДТГ/202301003 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 20000.00 (Хорин сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Ахмадын байрны засвар, үйлчилгээ”-ний ажлын 20000.00 (Хорин сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын “Ахмадын байрны засвар, үйлчилгээ” -ний ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан нөхцлийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлж 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Санхүүжилт: Бараа материалаа татаж авчирсаны дараа 70%, ажил гүйцэтгэж дуусаны дараа 30% -ийн нөхцөлтэй олгоно.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр **нийлүүлэгчид** төлөх үүрэг хүлээнэ.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

11. Ажлыг батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги нөгдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА

..... Ш.МӨНХ-ОРГИЛ

ХАЯГ: Дундговь аймгийн Цагаандэлгэр
сум Хараат 1-р баг

Утас: 95971666



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МӨНХӨЛЗИЙ АЛТ МӨНГӨН ГАДАС”

ХХК-НЫ ГИШҮҮН

Н.Өлзийбаяр н.ӨЛЗИЙБАЯР

ХАЯГ: Хэнтий аймаг Баянмөнх сум
4-р баг

Харилцах банк: Төрийн банк
250401851192

Регистрийн дугаар: 4206584

Утас: 99632704

